



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 634

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хүнс, хөдөө аж ахуйн бирж” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 7 нэрийн, нийт 6,699,500.00 (зургаан сая зургаан зуун ерэн есөн мянга таван зуу) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 3,486,680.00 (гурван сая дөрвөн зуун наян зургаан мянга зургаан зуун наян) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуйн бирж хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ц.Батсайханд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг ашиглалтын хугацаа сунгаж үнэ шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133622639

28-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
637 дугаар тогтоолын хавсралт

"ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ" ХХК-ИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж балансын үнэ	(төгрөг)			Цаашид ашиглах хугацаа /жил/
						Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ	Шинэчлэн тогтоосон нийт үнэ	
1	Буйдан /2 хүний /	2014-04-29	ш	2	684,200.00	1,368,400.00	620,000.00	1,240,000.00	2
2	Буйдан /3 хүний Ben Tasto/	2014-04-29	ш	1	2,033,900.00	2,033,900.00	500,000.00	500,000.00	2
3	Буйдан /3 хүний хар/	2014-05-16	ш	1	876,700.00	876,700.00	380,000.00	380,000.00	2
4	Хөргөгч /Toshiba GR-E1734/	2014-04-17	ш	1	489,900.00	489,900.00	319,960.00	319,960.00	2
5	Хөргөгч /Toshiba GR-E1834/	2014-04-17	ш	2	509,900.00	1,019,800.00	319,960.00	639,920.00	2
6	Ширээ /том шилэн KCO M6/	2014-05-16	ш	1	303,600.00	303,600.00	135,600.00	135,600.00	2
7	Ширээ /том шилэн M5/	2014-04-29	ш	2	303,600.00	607,200.00	135,600.00	271,200.00	2
	ДҮН			10		6,699,500.00 (зургаан сая зургаан зуун ерэн есөн мянга таван зуу)		3,486,680.00 (гурван сая дөрвөн зуун наян зургаан мянга зургаан зуун ная)	